




2024 MAR

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ АЛБА

ХУРААНГУЙ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2023Q4	2023Q3	2022Q4	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	30,454	21,695	28,455	7.0%
Ажилгүйдлийн түвшин	%	3.92%	5.24%	5.28%	-25.8%
Дундаж нэрлэсэн цалин	мянган төгрөг	2,235	2,009	1,750	27.7%
Гадаад өр	сая ам доллар	34,570	33,991	33,586	2.9%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M02	2024M01	2023M02	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам доллар	2,240	1,325	2,243	-0.1%
Зэс	сая ам доллар	445	220	372	19.7%
Нүүрс	сая ам доллар	1,336	803	1,268	5.4%
Нийт импорт	сая ам доллар	-1,596	-936	-1,198	33.2%
Хэрэглээ	сая ам доллар	-507	-304	-366	38.4%
Түүхий эд	сая ам доллар	-152	-83	-108	40.9%
Хөрөнгө оруулалт	сая ам доллар	-567	-349	-447	26.8%
Шатахуун	сая ам доллар	-367	-197	-275	33.2%
Тэнцэл	сая ам доллар	644	389	1,045	-38.4%
Дэлхийн түүхий эдийн үнэ					
Зэс	\$/тонн	8,305	8,351	8,937	-7.1%
Нүүрс	\$/тонн	129	141	244	-47.3%
Газрын тос	\$/баррель	82	79	84	-2.2%
Алт	\$/трой унц	2,024	2,034	1,853	9.2%
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцэл	тэрбум төгрөг	1,343	676	23	5849.4%
Төсвийн орлого	тэрбум төгрөг	5,102	2,731	2,787	83.1%
Төсвийн зардал	тэрбум төгрөг	-3,759	-2,054	-2,764	36.0%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M02	2024M01	2023M02	
Мөнгөний бодлого					
М2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	37,603	37,470	30,262	24.3%
ХҮИ (C2015)	индекс	141.6	140.6	132.3	7.0%
Бодлогын хүү	%	13.0%	13.0%	13.0%	0.0%
Хүү ба ханш					
Ам долларын ханш (Эцсийн)	Төгрөг/\$	3,382	3,401	3,522	-4.0%
Төгрөгийн хадгаламж	%	11.4%	11.4%	10.8%	5.3%
Валютын хадгаламж	%	3.9%	3.5%	2.3%	66.0%
Төгрөгийн зээл	%	17.0%	17.0%	16.0%	6.4%
Валютын зээл	%	9.4%	10.1%	8.3%	13.4%
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам доллар	4,971	4,849	3,395	46.4%
Үнэт цаас	сая ам доллар	2,148	2,242	798	169.3%
Харилцах, хадгаламж	сая ам доллар	2,145	1,928	2,153	-0.3%
ОУВС-д байршуулсан хөрөнгө	сая ам доллар	7	7	7	0.1%
Зээлжих тусгай эрх	сая ам доллар	101	105	117	-13.9%
Мөнгөжсөн алт	сая ам доллар	569	566	320	77.9%

Монголбанкны мөнгөний бодлогын хороо хуралдаж Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 12%-д хүргэх шийдвэр гаргалаа

- Инфляц алгуур буурч 2024 оны 2 сарын байдлаар улсын хэмжээнд 7%, Улаанбаатар хотын хэмжээнд 7.2% болж Монголбанкны зорилтот интервалд орж тогтворжсон нь бодлогын хүү буурахад голлон нөлөөлжээ. Харин суурь инфляц 2 сарын байдлаар 6.1% байгаа нь хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ өсөлттэй байгааг илтгэж байна. Энэ онд цалин, тэтгэвэр өсөх, ногдол ашиг тараах зэрэг шалтгаанаар инфляц өсөх эрсдэл өндөр байна.

АНУ-ын ХНС бодлогын хүүгээ 5.25-5.50 хувийн интервалд хэвээр хадгаллаа

- АНУ-ын бодлогын хүү сүүлийн 23 жилийн хамгийн өндөр түвшин буюу 5.25-5.50 хувийн түвшинд хэвээр хадгалагдаж байна. ХНС сүүлийн 5 удаагийн хурлаар бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэр гаргасан бөгөөд энэ онд хийсэн 2 дахь хуралдаа мөн хэвээр хадгалж үлдсэн ч 2024 онд 3 удаа хүүг бууруулна гэсэн шийдвэр өөрчлөгдөөгүй байна.

Дундаж тэтгэвэрийн хэмжээ 785,000 болж, нийт 499 мянган хүн хамрагдана.

- Нийгмийн даатгалын сангаас өндөр настны тэтгэвэр авагч иргэдийн тоо 499 мянга байгаа бөгөөд 4 сарын 1-с нийт тэтгэвэр авагчдын дундаж хэмжээ 785,000 болж өсөж байна. Харин төрийн албан хаагчдын цалингийн хувьд өнгөрсөн 2023 оны 7 сард 40%-иар өсгөсөн. Энэ оны 4 сараас төрийн албан хаагчдын цалинг 2 хэлбэрээр нэмэх бөгөөд үүнд төрийн бүх албан хаагчдын цалинг 10%, төрийн нийтлэг үйлчилгээний ажиллагсдын цалинг 20%-иар нэмэх аж. Ийнхүү нийт цалин тэтгэвэрт, энэ жил 881 тэрбум төгрөг зарцуулна.

Энэ онд ногдол ашгаар 1.9 их наяд төгрөг тараагдана

- Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниуд нийт 799 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараах бол Эрдэнэс тавантолгой ХК-ийн 1072 ширхэг хувьцааны ногдол ашгийн нийт хэмжээ 1.1 их наяд төгрөг байна. Үүний 290 тэрбум нь 2022 оны ашиг бөгөөд энэ оны 1 сарын 31-нд багтаан 1072 ширхэг хувьцаатай иргэн бүрт 104,400 төгрөг тараасан. Одоо 2023 оны ашгаас 970 тэрбум төгрөгийг 4 сарын 8-ны дотор тараагдахаар хүлээгдэж байна. Ийнхүү 1072 ширхэг хувьцаатай иргэн бүр дансандаа дахиад 256,000 төгрөгтэй (татварын дараах) болох нь.

Гадаад валютын албан нөөц түүхэн дээд түвшинд буюу 5 тэрбум ам.долларыг давлаа

- Гадаад валютын албан нөөц 2024 оны 3 сарын 15-ны байдлаар 5 тэрбум ам.долларт хүрсэн талаар Монголбанкнаас мэдээллээ. Гадаад валютын цэвэр дотогшлах урсгал сайжирч, гадаад валютын нөөц ийнхүү нэмэгдэх нь улсын зээлжих зэрэглэлд эерэгээр нөлөөлөх, хувийн хэвшлийн санхүүгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн төгрөгт итгэх итгэлийг нэмэгдүүлэх зэрэг олон эерэг талтай. Түүнчлэн 2 сарын байдлаар ГВАН-ийн валютын төлбөртэй импортын барааны хэрэгцээг хангах түвшин 7 сар болж өслөө.
- Манай улс эхний 2 сард нийт 121 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 3.8 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 2.2 тэрбум ам.доллар, импорт 1.6 тэрбум ам.долларт хүрч, тэнцэл 644.4 сая ам.долларын ашигтай гарчээ. Импорт өмнөх оны мөн үеэс 33 хувиар өсөхөд нийт автомашин, түлшний импортын өсөлт голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, энэ оны 3 сарын 25-ны байдлаар 32,585 автомашин импортолжээ.
- Нийт экспортын 59.7%-ийг чулуун нүүрс, 19.9%-ийг зэсийн хүдэр, баяжмал бүрдүүлж байна. Нүүрсний экспортын биет хэмжээ энэ оны эхний 2 сарын байдлаар 10 сая тонн давж, өмнөх оны мөн үеэс 30 гаруй хувиар өсжээ. Харин нүүрсний хилийн үнэ өмнөх сараас 11.4 ам.доллараар өсч, 131 ам.долларт хүрчээ.

Өрхийн бодит орлого 14.3%, бодит зардал 13.2%-иар өсжээ.


- 2023 оны жилийн эцсийн байдлаар нэрлэсэн өрхийн орлого өмнөх оноос 23.8%-иар өсч 2,286 мянган төгрөгт хүрсэн бол нэрлэсэн өрхийн зардал 22.6%-иар өсч 2,302 мянган төгрөг болжээ. Харин инфляцийн нөлөөг арилгасан бодит орлого, зардлын өсөлт тус бүр 14.3%, 13.2% байна.

Төлбөрийн тэнцэл 38.7 сая ам.долларын ашигтай гарлаа.

- Төлбөрийн тэнцэл гарахад гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж, санхүүгийн дансны тэнцэл 710 сая ам долларын ашигтай гарсан нь голлон нөлөөлжээ. Урсгал дансны тэнцэл 454.3 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгийн данс 20 сая ам.долларын ашигтай байна.


БОДИТ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

■ Бодит ДНБ-ны өсөлт (C2015)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛГҮЙДЭЛ БА ЦАЛИН




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Монголбанк

ДЭЛХИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ




Эх сурвалж: ОУВС

УЛСЫН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ГАДААД ӨР




Эх сурвалж: Монголбанк

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ




Эх сурвалж: Монголбанк

УЛСЫН ИНФЛЯЦ




Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ




Эх сурвалж: Монголбанк

АМ ДОЛЛАРЫН ХАНШ



Эх сурвалж: Монголбанк

БАНКУУДЫН ДУНДАЖ ХҮҮ



Эх сурвалж: Монголбанк



ЕРӨНХИЙ ЭДИЙН ЗАСАГЧ

Ө. Мөрөн

Цахим хаяг: murun_u@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Анунжин

Цахим хаяг: anunjin.ba@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Дархлан

Цахим хаяг: darkhlan@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

О. Номуншүр

Цахим хаяг: nomunshur@golomtbank.com

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны алба нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.